



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 72

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 53,701,256 /тавин гурван сая долоон зуун нэг мянга хоёр зуун тавин зургаа/ төгрөгийн балансын үнэтэй 6 ширхэг хөрөнгийн худалдах доод үнийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу тогтоон, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах, нийт 1,190,614,22 /нэг сая нэг зуун ерэн мянга зургаан зуун арван дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий барилга байгууламжийг хоёрдугаар хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Оюунханд)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Дуудлагын худалдааг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, орлогыг аймгийн хөрөнгө худалдсаны орлогын дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг аймгийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх.

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны нэгдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА




С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
32 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Өлзийт сум Засаг даргын Тамгын газрын дуудлага худалдаагаар худалдах
хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн төрөл	Марк	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	Бохирын машин	092162-98	1996	2018.12.30	15,000,000.	11,250,000.	3,750,000.	500,000.
2	Бага оврын шанаган трактор	092164-90	2013	2013.12.30	34,000,000.	34,000,000.	-	500,000.
3	Авто граж (Тагт багт)			1967.01.01	500,000.	500,000.	-	500,000.
4	Тэжээлийн агуулах			1967.01.01	500,000.	500,000.	-	1,000,000.
5	Станцын барилга			1967.01.01	2,693,040.	2,468,619,56	224,420.44	500,000.
6	Пүүний контор			2001.01.01	1,008,216.	1,008,216.	-	600,000.
7	Нийт дүн				53,701,256 /тавин гурван сая долоон зуун нэг хоёр зуун тавин зургаа/төгрөг	47,258,216 /дөчин долоон сая хоёр зуун тавин найман мянга хоёр зуун арван зургаа/ төгрөг	3,974,420.44 /гурван сая есөн зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун хорин төгрөг дөчин дөрвөн мөнгө/	3,600,000 /гурван сая зургаан зуу/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
72 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Өлзийт сум Засаг даргын Тамгын газрын актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Актлах төрөл 1 устгах 2 худалдах 3 сэлбэг материал түүхий эд болгох 4 бусад	
1	Хүлэмж	2001.01.01	ш	1	200,000	200,000	200,000	-	1	
2	Усан сан	1975.01.01	ш	1	630,000	630,000	630,000	-	1	
3	Бойны байшин	2012.09.30	ш	1	360,614,22	360,614,22	72,122,76	288,491,46	1	
Нийт дүн					3	1,190,614,22 /нэг сая нэг зуун ер зургаан зуун арван дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөг	1,190,614,22 /нэг сая нэг зуун ер зургаан зуун арван дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөг	902,122,76 /есөн зуун хоёр мянга нэг зуун хорин хоёр төгрөг далан зургаан мөнгө/ төгрөг	288,491,96 /хоёр зуун наян найман мянга дөрвөн зуун ерэн нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөг	